



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А/608

Арвайхээр

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр 29.2 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.5, 9.3.9, 9.3.10, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 03/02 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 4.2.1.1, “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 4.1.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Азийн хөгжлийн банкны ядуурлыг бууруулах Япон сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Арвайхээр хотын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах” төслийн хэрэгжилтэд хяналт тавих, шаардагдах мэдээ мэдээллээр хангах, үйл ажиллагааг эрчимжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Ч.Гүнсэнхорол (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Б.Бүзмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам зүй, хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн)

Б.Мөнхбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дэд бүтэц хариуцсан ахлах мэргэжилтэн)

Ч.Бат-Өлзий (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Газар, байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

С.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга)

Ж.Энх-Амар (Аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн газрын дарга)

А.Энхцэцэг (Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

011101287